



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/2/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: Утас: 88011833 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Азбаяр

Утас: 99061429 Цахим хаяг: Azbayarb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал.....	10
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	13
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16

Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

᠒᠐᠒᠐.᠐᠒.14 № 1/87

танай _____-ны № _____-т

Г Аудитын гэрчилгээ Г

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Х.БАТ-ОРГИЛ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020034

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

Аудитын тайлан

2.1. Оршил

Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Шүүхийн тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Бат-Оргил танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.01.28-аас 2020.01.31-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.13-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газар нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газар-т 2020.01.22-ний өдрийн 36 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Хүний эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтооно. Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндсэн хуульд байгууллагыг хамгаалах, хууль дээдлэх, шударга ёс, ардчилсан ёсыг бэхжүүлэх, хэрэг маргааныг хянан шийдвэрлэх замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, иргэний эрх зүйн ухамсар, соёлыг дээшлүүлэх, гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож болохгүй гэсэн эрхэм зорилго тодорхойлон ажиллажээ.

Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Шүүх ба олон нийтийн харилцааг бэхжүүлэх, эргэх холбоо тогтоох, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг дээшлүүлэх, шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангах, шүүхийн байгууллагын үйлчилгээнд олон нийтийн хяналтыг бий болгох.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газар нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" программ хангамж ашиглаж байна.

Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газар нь дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 32 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 32 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 983450,9 мянган төгрөгөөс тооцон 119669,0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 119669,0 мянган төгрөгөөр тооцсон нь үр дүнгийн тайлангийн зардлыг суурь болгон сонгосонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 26099,6 мянган төгрөгөөр буюу 4,2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	6802,2	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	28,010.0	30,469.4	-2.459,3
Үндсэн хөрөнгө	863,873.1	879902.6	-16,029.4
Үндсэн хөрөнгийн элэгдэл	-288,707.6	-326,493.7	-37,786.1
Нийт хөрөнгө	609,977.9	583,878.3	-26099.6
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	609,977.9	583,878,3	-26099.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	609,977.9	583,878,3	-26099.6

Авлага дансны үлдэгдэл 6802,2 мянган төгрөгөөр буурсан өмнөх оны авлагыг бүрэн барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2459,3 мянган төгрөгөөр өссөн байна. Төсвийн хөрөнгөөр бичиг хэргийн материал 12280,3 мянга, аж ахуйн материал 14071,1 мянга, түлш шатах тослох материал 16405,0 нийт 42756,4 мянган төгрөгийн худалдан авалт хийж, үнэ төлбөргүй 519,7 мянган төгрөгийн бичиг хэргийн материал авсан бөгөөд 40816,8 мянган төгрөгийн бараа материалын зарлага гаргаж 30469,4 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансанд 2019 онд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 35 ш 519,7 мянган төгрөгийн Вирусны программыг шилжүүлснийг бичиг хэргийн материалын дансанд бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өссөн бөгөөд төсвийн хөрөнгөөр 6222,3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 6345,0 мянган төгрөгөөр тавилга эд хогшил нийт 12567,3 мянган

төгрөгийн хөрөнгө, хандив тусламжаар 3413,5 мянга төгрөгийн тоног төхөөрөмж 27,3 мянган төгрөгийн номыг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс хандив тусламжаар ирсэн бөгөөд тайлант онд хөрөнгө актлаагүй байна.

Тайлант онд өр төлбөр дансаар 1076094,4 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэж тооцоо үүсгэсэн бөгөөд өр төлбөргүй ажилласан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 586878,2 мянган төгрөг болж -26099,6 мянган төгрөгөөр буурсан нь тайлан үеийн үр дүнгээр өөрчлөлт орсон байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газар нь тайлант онд өөрийн орлого төлөвлөөгүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 6 зориулалтад 952169,5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 952169,5 мянган төгрөгийг урсгал зардал зарцуулахаар батлагджээ.

Тайлант онд нийт 952169,5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас улсын төсвөөс 95169,5 мянган төгрөгийн санхүүжилт авахаар батлагдсан ба гүйцэтгэлээр 952169,5 мянган төгрөгийн санхүүжилт буюу улсын төсвөөс авах санхүүжилтийг бүрэн авч бөгөөд бусад орлогоор 1200,0 мянган төгрөг төвлөрсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 946841,7 мянган төгрөг буюу 99,4 хувьтай байгаагаас гол хэмнэгдсэн зардал нь цалин түүнтэй адилтгах орлого 3595,4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 831,6 мянга, томилолтын зардал 890,1 мянган, бусад орлого 1200,0 мянга нийт 6527,7 мянган төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна. Цалингийн зардал хэмнэгдсэн шалтгаан нь шүүгч жирэмсний амралт авсан, Шүүн таслах ажиллагаанд оролцсон иргэдийн төлөөлөгчдийн ажлын хөлс, томилолтын зардал тайлант оны гүйцэтгэлээр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 32 эрсдэл тодорхойлж нийт 32 горим сорил хэрэгжүүллээ.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 32 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 31 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Аудитаар нийт 6331,0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 6331,1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Тайлант оны шилэн дансны мэдээллээс сар бүр мэдээлэх байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг 9 сард, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлийг 7 сард, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт 7 сард, бүтэн жилээр байршуулах Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө-1, тухай бүр байршуулах Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ 9 сард тус тус хоцроож мэдээлсэн байна

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуул аагүй
1	Бүтэн жил	11	11	11	1	0
2	Хагас жил	4	4	4	0	0
3	Улирал бүр	1	4	4	0	0
4	Сар бүр	3	36	36	3	0
5	Тухай бүр	8	96	92	1	0
6	Нийт	27	151	147	5	0

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тайлант хугацаанд цалинтай холбоотой авлага үүсгэхгүй байх зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийг 100% хэрэгжүүлж ажиллаж тайлант онд авлагыг бүрэн барагдуулж авлага үүсгээгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. *Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл*

1.1. Илрүүлэлт:

Цалингийн зардлыг 6331,1 мянган төгрөгөөр ажил олгогчоос төлөх НДШ-ээс гүйлгэн зарцуулсан.

1.2. Эрсдэл:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй

1.3. Өгсөн зөвлөмж:

Зардлыг хуульд заасан хувь хэмжээг харгалзан үзэж бодитой төлөвлөн зардал гаргахдаа Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-ыг мөрдөж ажиллах дахин давтаж гаргахгүй байх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 5 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>34,812,344.55</u>	<u>30,469,424.00</u>
33	АВЛАГА	6,802,270.55	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,000,000.00	00.00
335	Бусад авлага	5,802,270.55	00.00
3351	Байгууллагаас авах авлага	5,802,270.55	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	28,010,074.00	30,469,424.00
354	Хангамжийн материал	28,010,074.00	30,469,424.00
35410	Бичиг хэргийн материал	3,961,596.00	4,184,146.00
35420	Аж ахуйн материал	21,728,178.00	23,969,978.00
35440	Түлш, шатах тослох материал	995,000.00	990,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,325,300.00	1,325,300.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>575,165,570.93</u>	<u>553,408,873.39</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	575,165,570.93	553,408,873.39
392	Биет хөрөнгө	512,421,820.97	490,747,073.47
39201	Барилга, байгууламж, орон сууц	488,335,355.19	488,335,355.19
39202	Хуримтлагдсан элэгдэл	-32,786,082.01	-54,824,644.33
39203	Авто-тээврийн хэрэгсэл	78,936,000.00	78,936,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-75,936,000.00	-76,686,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	146,078,901.01	155,714,668.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	-127,825,298.16	-136,227,121.35
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	84,413,235.12	90,758,235.12
39208	Хуримтлагдсан элэгдэл	-51,491,990.18	-58,005,779.17
39214	Бусад үндсэн хөрөнгө	189,400.00	189,400.00
39217	Ном	2,508,300.00	2,556,960.00
393	Биет бус хөрөнгө	62,743,749.96	62,661,799.92
39301	Програм хангамж	891,000.00	891,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-668,250.04	-750,200.08
39303	Бусад биет бус хөрөнгө	62,521,000.00	62,521,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>609,977,915.48</u>	<u>583,878,297.39</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>609,977,915.48</u>	<u>583,878,297.39</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	609,977,915.48	583,878,297.39
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	818,720,719.00	818,720,719.00
51101	Өмч: - төрийн	818,720,719.00	818,720,719.00
512	Хуримтлагдсан үр дүн	-247,354,994.28	-273,454,612.37
51210	Өмнөх үеийн үр дүн	-247,354,994.28	-247,354,994.28
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-26,099,618.09
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	38,612,190.76	38,612,190.76
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>609,977,915.48</u>	<u>583,878,297.39</u>

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	912,814,500.49	957,351,367.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,718,800.49	5,181,867.00
120	Нийтлэг татварын бус орлого	11,718,800.49	5,181,867.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,718,800.49	5,160,567.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	455,920.49	1,200,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	11,262,880.00	3,960,567.00
120009	Бусад орлого	00.00	21,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	901,095,700.00	952,169,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	899,095,700.00	952,169,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	899,095,700.00	952,169,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,000,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	934,530,178.05	983,450,985.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	934,530,178.05	983,450,985.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	926,329,284.05	974,933,280.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	678,037,083.45	748,630,621.29
210101	Үндсэн цалин	596,598,410.45	634,092,880.29
210102	Нэмэгдэл	45,523,583.00	72,251,143.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,077,100.00	21,425,314.00
210104	Урамшуулал	17,837,990.00	20,861,284.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,777,990.49	86,716,687.55
210201	Тэтгэврийн даатгал	50,571,527.69	56,840,587.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,859,325.00	7,469,000.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,306,219.45	5,437,055.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,413,698.00	2,031,945.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,627,220.35	14,938,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,921,263.00	40,630,000.00
210301	Гэрэл, цахилгаан	5,294,414.00	4,984,609.00
210302	Түлш, халаалт	34,991,119.00	32,928,708.00
210303	Цэвэр, бохир ус	2,635,730.00	2,716,683.00
2104	Хангамж, бараа материалын зардал	49,300,025.00	46,200,650.00
210401	Бичиг хэрэг	12,461,930.00	12,632,000.00
210402	Тээвэр, шатахуун	15,410,000.00	16,410,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,943,000.00	9,328,840.00
210404	Ном, хэвлэл	186,800.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	240,000.00

**Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,118,295.00	7,589,810.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,598,532.00	7,316,180.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,140,000.00	907,980.00
210604	Урсгал засвар	12,458,532.00	6,408,200.00
2107	Томилолт, зочны зардал	8,763,100.00	5,094,150.00
210702	Дотоод албан томилолт	8,763,100.00	5,094,150.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,287,502.00	2,558,867.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,516,602.00	609,621.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	660,100.00	847,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	88,800.00	141,746.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	247,500.00
210807	Газрын төлбөр	00.00	369,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,643,788.11	37,786,124.54
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,999,820.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	47,643,968.11	37,786,124.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,200,894.00	8,517,704.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	1,990,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,990,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,200,894.00	6,527,704.71
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,200,894.00	6,527,704.71
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-21,715,677.56	-26,099,618.09
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	55,381,820.95	00.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	55,381,820.95	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-55,381,820.95	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-77,097,498.51	-26,099,618.09

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	912,508,205.00	953,369,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	1,200,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	1,200,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,200,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	912,508,205.00	952,169,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	899,095,700.00	952,169,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	899,095,700.00	952,169,500.00

Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,000,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	11,412,505.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	11,412,505.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	906,596,205.00	940,802,190.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	906,596,205.00	940,802,190.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	886,982,806.00	932,284,485.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	684,839,354.00	736,307,238.29
210101	Үндсэн цалин	562,505,574.00	595,343,399.29
210102	Нэмэгдэл	80,247,012.00	93,466,555.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,287,100.00	26,636,000.00
210104	Урамшуулал	17,799,668.00	20,861,284.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,322,070.00	92,237,800.00
210201	Тэтгэврийн даатгал	53,617,607.00	62,361,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,976,820.00	7,469,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,746,921.00	5,975,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,265,343.00	1,493,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,715,379.00	14,938,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,921,263.00	40,630,000.00
210301	Гэрэл, цахилгаан	4,264,414.00	4,984,609.00
210302	Түлш, халаалт	36,021,119.00	32,928,708.00
210303	Цэвэр, бохир ус	2,635,730.00	2,716,683.00
2104	Хангамж, бараа материалын зардал	45,655,665.00	41,274,200.00
210401	Бичиг хэрэг	12,280,900.00	12,335,200.00
210402	Тээвэр, шатахуун	16,405,000.00	16,405,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,943,000.00	9,328,840.00
210404	Ном, хэвлэл	186,800.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	90,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,659,965.00	3,115,160.00
2105	Нормативт зардал	798,700.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	798,700.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,395,332.00	13,232,230.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,806,000.00	1,557,580.00
210604	Урсгал засвар	14,589,332.00	11,674,650.00
2107	Томилолт, зочны зардал	8,763,100.00	5,094,150.00
210702	Дотоод албан томилолт	8,763,100.00	5,094,150.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,287,502.00	2,708,867.00

**Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,516,602.00	759,621.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	660,100.00	847,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	88,800.00	141,746.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	247,500.00
210807	Газрын төлбөр	00.00	369,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,999,820.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,999,820.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,613,399.00	8,517,704.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,412,505.00	1,990,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	11,412,505.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,990,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,200,894.00	6,527,704.71
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,200,894.00	6,527,704.71
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>5,912,000.00</u>	<u>12,567,310.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>5,912,000.00</u>	<u>12,567,310.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>5,912,000.00</u>	<u>12,567,310.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	<u>5,912,000.00</u>	<u>12,567,310.00</u>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,912,000.00	12,567,310.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-5,912,000.00</u>	<u>-12,567,310.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	818,720,719.00	38,612,190.76	-247,354,994.28	00.00	609,977,915.48
D02	Нягтлан бодох бүртгэлийн	00.00	00.00	00.00	00.00	00.00

**Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	756,199,719.00	36,226,790.65	-170,257,495.77	622,169,013.88
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	2,385,400.11	00.00	2,385,400.11
C05	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	62,521,000.00	00.00	00.00	62,521,000.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-77,097,498.51	-77,097,498.51
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	818,720,719.00	38,612,190.76	-247,354,994.28	609,977,915.48
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	818,720,719.00	38,612,190.76	-247,354,994.28	609,977,915.48
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	818,720,719.00	38,612,190.76	-247,354,994.28	609,977,915.48
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-26,099,618.09	-26,099,618.09
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	818,720,719.00	38,612,190.76	-273,454,612.37	583,878,297.39

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	899,095,700.00	890,894,806.00	952,169,500.00	946,841,795.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	899,095,700.00	890,894,806.00	952,169,500.00	946,841,795.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	896,795,700.00	890,894,806.00	950,169,500.00	944,851,795.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	684,840,200.00	684,839,354.00	739,902,700.00	736,307,238.29
210101	Үндсэн цалин	561,857,200.00	562,505,574.00	601,075,400.00	595,343,399.29
210102	Нэмэгдэл	85,642,000.00	80,247,012.00	101,555,900.00	93,466,555.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,942,000.00	24,287,100.00	23,453,000.00	26,636,000.00
210104	Урамшуулал	12,399,000.00	17,799,668.00	13,818,400.00	20,861,284.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,181,000.00	80,322,070.00	92,237,800.00	92,237,800.00
210201	Тэтгэврийн даатгал	53,540,400.00	53,617,607.00	62,361,700.00	62,361,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,160,200.00	6,976,820.00	7,469,000.00	7,469,000.00

**Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,299,800.00	42,921,263.00	40,630,000.00	40,630,000.00
210301	Гэрэл, цахилгаан	4,275,900.00	4,264,414.00	2,976,600.00	4,984,609.00
210302	Түлш, халаалт	36,023,900.00	36,021,119.00	35,122,800.00	32,928,708.00
210303	Цэвэр, бохир ус	3,000,000.00	2,635,730.00	2,530,600.00	2,716,683.00
2104	Хангамж, бараа материалын зардал	45,964,200.00	46,068,665.00	41,274,200.00	41,274,200.00
210401	Бичиг хэрэг	12,335,900.00	12,280,900.00	12,335,900.00	12,335,200.00
210402	Тээвэр, шатахуун	16,405,300.00	16,405,000.00	16,405,300.00	16,405,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,943,000.00	11,943,000.00	9,443,000.00	9,328,840.00
210404	Ном, хэвлэл	600,000.00	599,800.00	00.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хоргон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	180,000.00	90,000.00	90,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,500,000.00	4,659,965.00	3,000,000.00	3,115,160.00
2105	Нормативт зардал	800,000.00	798,700.00	800,000.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	798,700.00	800,000.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,000,000.00	22,894,332.00	25,800,000.00	25,799,540.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,000,000.00	7,055,000.00	12,000,000.00	13,484,890.00
210604	Урсгал засвар	16,000,000.00	15,839,332.00	13,800,000.00	12,314,650.00
2107	Томилолт, зочны зардал	9,284,300.00	8,763,100.00	5,984,300.00	5,094,150.00
210702	Дотоод албан томилолт	9,284,300.00	8,763,100.00	5,984,300.00	5,094,150.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,426,200.00	2,287,502.00	3,540,500.00	2,708,867.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,571,100.00	1,516,602.00	1,571,100.00	759,621.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00	300,000.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	660,100.00	660,100.00	847,000.00	847,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	165,000.00	88,800.00	161,900.00	141,746.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	22,000.00	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	00.00	247,500.00	247,500.00
210807	Газрын төлбөр	00.00	00.00	369,000.00	369,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2000000.00	1999820.00	0.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	1,999,820.00	00.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2300000.00	0.00	2000000.00	1990000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,300,000.00	00.00	2,000,000.00	1,990,000.00

**Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,300,000.00	00.00	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	00.00	2,000,000.00	1,990,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	779,298,600.00	774,551,168.00	952,169,500.00	952,169,500.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	779,298,600.00	774,551,168.00	952,169,500.00	952,169,500.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	779,298,600.00	774,551,168.00	952,169,500.00	952,169,500.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	01.00	01.00
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	01.00	01.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	38.00	37.00	38.00	38.00
620001	Удирдах ажилтан	05.00	05.00	05.00	05.00
620002	Гүйцэтгэх ажилтан	29.00	28.00	29.00	29.00
620003	Үйлчлэх ажилтан	04.00	04.00	04.00	04.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	35.00	37.00	38.00	38.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	16.00	16.00	16.00	16.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	09.00	11.00	12.00	12.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10.00	10.00	10.00	10.00

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР:

Б.АЗБАЯР 2020.02.14

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЭНЯМ 2020.02.14

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ 2020.02.14